

СОЦИОЛОГИЙН ОНОЛЫН ЗАЛГАМЖ ХОЛБООНЫ ТАЛААРХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

*Ш.Оюунханд
Социологи ухааны доктор (PhD)*

Эдүгээ социологийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлалууд нь нийгмийн хөгжил, шинжлэх ухааны шинэ нээлтүүдтэй холбоотойгоор асар хурдацтай өөрчлөгдөхийн зэрэгцээ, нийгмийн харилцаа холбоо, нийгмийн солилцоо, итгэлцэл, онолын рациональч ба иррациональ чиг баримжааг харилцан уялдаатайгаар тайлбарлах болж, социологид социологийн дунд түвшний онолын загварууд түлхүү байр суурь эзлэх болжээ. Дээрхээс үүдэн социологийн шинжлэх ухааны тэргүүлэх зорилго, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх сонгодогуудын тайлбарлалд тодорхой хэмжээний өөрчлөлтүүд бий болсоор байгаа бөгөөд үүнтэй санал нийлэх судлаачид олонтоо тохиолдох болсон нь зүйн хэрэг юм.

Орчин үеийн социологийн онолын түүхийг судлаачдын нэг болох Германы социологич Анет Трайбел: Социологийн шинжлэх ухааны гол зорилго, үүрэг нь нийгмийн нэгэнт бий болон үйлчилж буй бодит харилцаан дунд аж төрөн амьдарч, уран бүтээлээ туурвин, үйл ажиллагаагаа явуулж байгаа хүмүүсийн хоорондын харилцааг судлахад чиглэгддэг хэмээн тодорхойлсон байдаг. Үүнээс үүдээд орчин үеийн социологийн судлагдахууныг доорх байдлаар тодорхойлж болно.

- Нийгмийн шинж чанар, шинж төлөвийг тодорхойлохдоо бичиглэн тоочих, статистик аргаар хязгаарлагдаад зогсохгүй нийгэмд өрнөж буй үзэгдэл үйл явцуудад шинжилгээ хийхдээ түүний учир шалтгааныг тодруулан тайлбарлах
- Нийгмийн харилцаа, холбоо, нийгэм дэх хамтын нийгэмлэг, нийтлэгүүд, бүлгийн гишүүдийн холбоо сүлбээнд анализ хийх
- Хувь хүн болон бүлгийн хоорондын харилцааг нийгмийн бүтэцтэй холбон үзэх чиг баримжаа давамгайлах шинжтэйгээр хөгжиж байна.

Харин социологийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлалуудын гол зорилго нь: Нийгмийн хөгжлийн төлөв байдал, чиг хандлагыг тайлбарласан, тодорхойлсон онол арга зүйн загварыг боловсруулахад оршино. Чингэхдээ социологийн өвөрмөц онцлогийг тусгасан аргачлал, ойлголт ухагдахуун, арга техникийг ашиглах нь дамжиггүй. Социологийн аль ч үеийн онолуудын хооронд нүдэнд үл үзэгдэх сэжим, холбоо оршин байдаг бөгөөд тэдгээрийн аль аль нь түүхэн нөхцөл, цаг хугацаа, орон зай, үндэсний онцлогтой холбоотой, энэ л суурин дээр боловсорч бий болсон, түүнийхээ ч онцлогийг шингээсэн байдаг. Тодруулбал, аль ч тодорхой онолыг аваад үзсэн онолын тодорхой эх сурвалж, утгар, залгамж холбооны талаар ярьж болно.

Асуудлын гол нь эдгээр онолууд түүхэн цаг хугацааны туршид, шинэ ойлголт, арга техник, онол арга зүйгээр баяжин хөгжиж, улам боловсронгуй болон төгөлдөржиж, цаг үеийнхээ онцлог, тулгамдсан шинжтэй асуудлуудыг шийдвэрлэж байдаг оршдог. Тиймээс ч орчин үеийн социологийн онол, үзэл баримтлалуудыг ойлгох, танин мэдэхэд түүний түүхэн өмнөтгөл болдог социологийн сэтгэлгээний түүхийн илэрхийлэл сонгодог үеийн талаарх ойлголт мэдлэг асар чухал ач холбогдолтой. XIX зууны 50-60-аад онд, эдүгээ сонгодог бүтээл “Капитал”-аа туурвихдаа ч Карл Маркс нэг талаас тухайн үеийн Английн нийгэм эдийн засгийн системийн асар эрчтэй аж үйлдвэржилтийн үйл явц, нөгөөтэйгүүр Английн ажилчин ангийн үгүйрэл, хоосрол, үгээгүй байдал нь туйлдаа хүрсэн түүхэн нөхцөлтэй холбон авч үзсэн байдаг. Түүнээс хойш, даруй 140-өөд жилийн туршийн тасралтгүй хөгжлийн дунд барууны төдийгүй бүхий л нийгэмд техник, улс төрийн хувьсгал өрнөн, асар их өөрчлөлт хувьсалд орсон.

Энэ тухайд ч олон судлаачид судалгаа шинжилгээ, бүтээл нийтлэлүүддээ тусган өөр өөрсдийн тайлбарлал, онол арга зүйг тодорхойлсон нь бий. Хэдийгээр сонгодог үеийн “канон”-д нэрс нь ямар ч маргаангүй аксиом байдлаар бичигддэг судлаачдын жагсаалтад өнөөгийн өндөрлөгөөс, тухайлбал, хүйсийн, шашны, расизмын үүднээс шүүмжлэлтэй хандаж болох ч, тэдгээрийн онолын хөгжлийн

эволюци хөгжилд гүйцэтгэсэн үүргийг үгүйсгэх аргагүй юм. Гагцхүү түүний цаана олон тооны социологичид оршин, үзэл бодол, байр сууриа илэрхийлэн, энэхүү шинжлэх ухааны хөгжилд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулж байсан нь орчин үеийн нийгмийн харилцааны аль нэг тулгамдсан асуудлыг гүнзгийрүүлэн судлахад улам бүр ойлгомжтой болдог. (Мишель Фуко, Ч.Миллс, Мариана Вебер . . .)

Орчин үеийн социологичид, тэдний үзэл баримтлал нь өнөөдөр, энэ цаг мөчид нийгмийн өмнө тулгараад бус асуудлуудыг судлахад чиглэгдэж байгаа гэдэг утгаараа нэлээд шинэлэг, тулгамдсан хэдий ч тэд онолын хувьд хэзээ ч өмнө нь байгаагүй цоо шинэ зүйлээс гараагаа эхэлдэггүй. Дийлэнхдээ өмнө нь боловсруулсан үзэл баримтлал, онол арга зүйд тулгуурлан, тайлбарлал хийх, бүтээлчээр тунгаах, зарим тохиолдолд өөрсдөө ч мэдэлгүй баталгаа нотолгоондоо сонгодогуудаас ашигладаг. Учир нь сонгодог социологичдын онол концепцууд нь онол арга зүйн уламжлалыг бүрдүүлэхийн сацуу, автоматаар (сургалт, боловсрол, уншсан зүйлс . . .) бидний оюун ухаан, ой тойнд хадгалагдан үлдсэн байдаг учраас, шинжилгээ хийх, түүнийг үндэслэх, учир шалтгааны тайлбарлалыг олж тогтоохдоо хүссэн ч хүсээгүй ч тархи толгойдоо шингэсэн сонгодог загварыг ашигласан байдаг. Тэртээ, одоогоос барагцаалбал 150-аад жилийн өмнө О.Конт социологи хэмээх нэр томъёог шинжлэх ухааны эргэлтэнд оруулж ирэн, харьцангуй автономн шинжтэй оршигч шинжлэх ухаан хэмээн тодорхойлсон билээ. Түүхийн он удаан жилийн хүрдэн тойргийн үүднээс үзвэл энэ нь хэдийгээр төдийлөн урт хугацаа биш ч, энэ хугацаанд социологи нь статусын, онол арга зүйн, арга техникийн, нийгмийн хэрэглээний хувьд үлэмж их зүйлийг амжуулж, нэгэнт академик түвшний шинжлэх ухаан болтлоо хөгжжээ. Үүнд социологичдын сонгодог болон орчин үеийн төлөөлөгчдийн оюун санаа, бүтээл туурвилын залгамж холбоо үнэлж барахгүй чухал үүрэг гүйцэтгэсэн нь ойлгомжтой.

“Орчин үе” хэмээх ойлголт нь өөрөө байнга өөрчлөгдөн хөгжиж байдагтай холбоотойгоор эдүгээ 60-70-аад оны үеийг 90-ээд оны үетэй харьцуулбал, 90-ээд он ч орчин үетэйгээ харьцуулбал, социологийн онолын хөгжлийн түүх болох жишээтэй. Энэ ч үүднээсээ орчин үеийн социологийн онолыг ойлгох, онолын үзэл баримтлалын тулгамдсан байдлыг тодорхойлоход доорх хэд хэдэн бэрхшээлтэй асуудлууд үүсдэг.

- Орчин үеийн социологичид нь өөрсдөө тухайн цаг үедээ амьдран, үйл ажиллагаа, үзэл баримтлалаа хөгжүүлэхийн сацуу, бүтээл нийтлэлээ туурвин, ойлголтын тайлбарлал, тезисүүдээ улам боловсронгуй болгон өөрчилж, засч залруулж байдаг. Тэр ч утгаараа онолын бүрэн төгс боловсорсон схемийн талаар ярих нь огтоос утгагүй бөгөөд энэ ч утгаараа асуудлууд дийлэнхдээ нээлттэй, асуудал дэвшүүлсэн, санал болгож буй хувилбар байдлаар яригддаг. Энэ ч тухайн судлаачдад аль нэг онолын загварт ягштал баригдалгүй цаг хугацаа, цуглуулсан туршлага, бий болсон нөхцөл байдалд уян хатнаар хандах, мэдрэмжтэй байх, харьцуулах, өөрийн үнэлэмж дүгнэлтийг бусдад тулгахгүй байх бололцоог олгодгоороо давуутай. Онолын чиглэлээр хэвлэгдэн нийтлэгдэж буй бүтээл нийтлэлүүд дэх багш, судлаачдын баримталж, дэвшүүлж буй хувилбарууд нь ч тухайн зохиогчдынхоо хувьд “эргэлзээгүй”, итгэлтэй шинжийг агуулдаггүй.
- Орчин үеийн социологи нь “канончлох” боломжгүй. Зөвхөн болзмол байдлаар орчин үеийн социологи дахь сонгодогууд (60-70 аад он)-ын хүрээнд л мэргэжлийн бүтээл нийтлэл, ном зохиол нь хэр академик хүрээнд, хэр танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн, бусадтай харьцуулбал ямар давуу талуудтай (зөвхөн социологичдоос гадна), хэвлэн нийтлүүлсэн зохиол бүтээл, ном нь энэ чиглэлийн сургалтанд одоогийн байдлаар хэр хэрэгцээтэйгээр ашиглагдаж байгаа, их дээд сургуулийн багш нар тухайн зохиогчийн мэргэшсэн мэдлэгийн талаарх үнэлэмж зэрэг цөөн шалгуураар л тодорхойлогдож болох юм.
- Социологийн сэтгэлгээний түүхийн нэгэн адил социологичдын он дараалсан товчооныг гаргах боломжгүй. Гиймээс ч орчин үеийн социологийн онолыг системчлэх асуудал нь туйлын хүндрэлтэй учраас, онол арга зүйн чиг баримжааны тэргүүлэх шинжээр нь онолын макро, микро, интеграль (дуаль) хэмээх хандлагуудыг шалгуур болгон тайлбарлах хандлага зонхилж байна.